



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/86

Мандалговь

“Модернхас” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”- 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 1 дугаар сарын 22-ны өдрийн А/19 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Бүрдийн уянга зуслангийн гадна төмөр хашааны ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Модернхас” ХХК-тай 60,880,880 (жаран сая найман зуун наян мянга найман зуун наян) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг, төсвийн дагуу Бүрдийн уянга зуслангийн гадна төмөр хашааны ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Модернхас” ХХК-ны гүйцэтгэх захирал (С.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын дарга (Ц.Ганзориг), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ЭРДЭНЭСҮРЭН



482060334